

## МУИС-ийн ГХСС-ийн оюутны орчуулгын анхдугаар уралдаан

ГХСС-ийн Орчуулгазүйн Профессорын хамтлаг байгуулагдсантай холбогдуулан тус сургуулийн нийт оюутнуудын дунд эзэмших мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, цаашдын уран зохиолын орчуулга хийхэд нь дөхөм болох, багш оюутан ба оюутан хоорондын хамтран ажиллах, бие биеэсээ суралцах, оюутны орчуулах дадлыг сайжруулах, цаашид орчуулгын нөр их ажил хийх идэвх зүтгэлийг нь хөхүүлэн дэмжих үүднээс тус сургуулиас зааж мэргэшүүлдэг олон хэл рүү Д.Нацагдоржийн “Хуучин хүү” зохиолыг орчуулах уралдааныг анх удаа зохион явууллаа.

Энэхүү уралдаанд оролцсоноор оюутан өөрийнхөө дотоод нөөц чадавхийг нээн илрүүлж, үүнийгээ нийтэд үзүүлэх боломжийг бий болгосон бөгөөд, эзэмшиж буй хэлээр яригч ард түмний соёлыг эх соёлтойгоо харьцуулах, өөрийн соёлын онцлогийг бусдад таниулахад энэ уралдаан зохих үр дүнгээ өгсөн нь дамжиггүй. Цаашид монголын сонгодог бүтээлээс бусад хэлэнд орчуулах уралдааныг уламжлал болгон жил бүр зохион явуулах бөгөөд шилдэг орчуулгыг хэвлэн, нийтийн хүртээл болгох ба сургалт судалгаанд ашиглах орчуулгын сан бүрдүүлэхэд ашиглах юм. Уралдааны зорилго нь эх хэлнийхээ баялаг яруу өгүүлэмжийг гадаад хэлэнд оновчтой буулгах оюутны чадварыг хөгжүүлэх, оюутанд бичгийн орчуулгын дадал, туршлага суулгахад оршино.

Хэл тус бүрээр шалгаруулах комисст орсон багш нар уралдаанд ирүүлсэн орчуулгуудыг хянан, дүгнэлтээ гарган, 2013 оны 3-р сарын 6-нд Орчуулгазүйн профессорын хамтлагийн хурлаар хэлэлцэн, орчуулсан хэл тус бүрт 1, 2, 3-р байрын ялагчдыг тодруулсан бөгөөд 2013 оны 3-р сарын 14-нд “Оюутны орчуулгын анхдугаар уралдаан”-ы дүнгийн ёслолын хурлыг хийж, оюутанд цом, мөнгөн шагналыг гардуулсан юм. Оюутны орчуулгын уралдаанд байр эзэлсэн оюутны нэрс:

- |           |  |
|-----------|--|
| 1-р байр: | Орос хэлний 1-р анги Б.Номин<br>Чех хэлний 3-р анги А.Батчимэг<br>Франц хэлний 2-р анги Ц.Бадамханд<br>Англи хэлний 3а анги Б.Энхтүшиг<br>Хятад хэлний 1а анги Б.Батцэцэг<br>Герман хэлний 4-р анги Ц.Мөнхбуянт<br>Испани хэлний 2-р анги Г.Сарнай |
| 2-р байр: | Орос хэлний 1-р анги Ч.Эрдэнэбаатар<br>Чех хэлний 2-р анги О.Үүрийнтуяа<br>Франц хэлний 3-р анги Д.Золзаяа<br>Англи хэлний 4б анги Т.Ган-Эрдэнэ<br>Хятад хэлний 4а анги Г.Энхмэнд<br>Солонгос хэлний 4-р анги О.Номин                              |
| 3-р байр: | Франц хэлний 3-р анги Б.Дондов<br>Английн 2а анги Э.Ууганцэцэг<br>Хятад хэлний 4а анги А.Ундраа  |